



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 8/246

Номгон

Баянхонгор аймгийн Засаг дарга Э.Энхбатын
ивээл дор зохион байгуулагдах граунд
гольфийн тэмцээнд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.6, 13.1.9, Ахмад настны тухай хуулийн 7.2.13, 11.1.2, Аймгийг хөгжүүлэх 2026-2030 оны үндсэн чиглэлийн 1.2.2.2, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Ахмад настуудын нийгмийн идэвх оролцоо, хөгжлийг дэмжих зорилго бүхий граунд гольфийн тэмцээнийг 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тэмцээний мөнгөн шагнал, медаль, өргөмжлөл, шүүгчдийн урамшуулал, бусад зохион байгуулалтад шаардагдах 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Шаардагдах төсвийн зарцуулалтыг хавсралтаар баталсугай.


4. Граунд гольфийн тэмцээнийг хариуцлагатай зохион байгуулахыг Биеийн тамир, спортын газар (Б.Хүрэлчулуун)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

626010647

Аймгийн Засаг даргын 2006 оны 04 дүгээр
сарын 22-ны өдрийн 47246 дугаар
захирамжийн хавсралт



АХМАД НАСТНУУДЫН ГРАУНД ГОЛЬФИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

№	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Медаль	28	18000	504,000	
2	Өргөмжлөл	28	10,600	299,000	
3	Багийн шагнал	7 баг	171,000	1,197,000	
Нийт дүн				2,000,000	

_____оОо_____